

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын огноо: 2021 оны 4 сарын 28-ны өдөр

Хурлын байршил: live.ard.mn цахимаар хаягаар хуралдав.

Хурал эхэлсэн цаг: 14 цаг 00 минут

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуяг

Хурлын ирц: Нийт саналын эрхтэй хувьцааны тоо 25,000,000 ширхэг, хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо 17,680,039 ширхэг буюу 70.72 хувь

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2020 онд олгосон ногдол ашгийн тайлан танилцуулах;
3. 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай;

ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг: Ард Даатгал ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчид, үйлчлүүлэгчид та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ард Даатгал компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуяг байна. Ард Даатгал компанийн хувьцаа эзэмшигчдийн хувьд хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2021 оны 3 сарын 31-ний өдрөөр тасалбар болгож хуралд оролцох форм бөглөсөн хувьцаа эзэмшигчдэдээ өчигдөр болон өнөөдөр хүргүүлсэн кодын дагуу хуралдаа оролцож байна. Мөн өнөөдрийн байдлаар хувьцаа эзэмшигч болж нэмэгдэж орж ирсэн, эсвэл компанийн үйл ажиллагааг сонирхож буй иргэд, эсвэл хувьцаа эзэмшигч болохыг сонирхож буй иргэд, эсвэл нээлттэй хувьцаат компанийн цахим хурал хэрхэн явагдаж буйг сонирхсон иргэд компанийн сошиал хаяг буюу facebook live ([https://www.facebook.com/watch/live/?v=906583373530526&ref=watch_permalink\)-p](https://www.facebook.com/watch/live/?v=906583373530526&ref=watch_permalink)-p) цацагдаж буй live-р орж хуралд оролцох боломжтой. Хурлын ирцийг танилцуулах, хурлын үйл явцыг ажиглах зорилгоор оролцож буй зочин өөрийгөө танилцуулах уу?

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Ард Даатгал компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэнд хүргэе. Манай Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК нь өнөөдрийн Ард Даатгал компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссоор ажиллаж байна. Энэ удаагийн хурал нь цахимаар явагдаж

байгаатай холбогдон цахим аюулгүй байдлыг хангах, хөндлөнгийн хяналт тавихаар Дефофф ХХК хамтран ажиллаж байна.

ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг: За баярлалаа. ТУЗ-ийн гишүүдээ танилцуулъя.

ТУЗ-ийн гишүүд өөр өөрсдийгөө танилцуулав.

ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг: За одоо тэгвэл хурлынхаа ажлыг эхлүүлье. Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолыг танилцуулъя. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн тогтоох нь: Саналын эрх бүхий энгийн хувьцааны 17,680,039 ширхэг буюу 70.72 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр хэсгийг үндэслэн тус хурал хүчин төгөлдөр болно.

ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг: За баярлалаа. Хурлын ирцийг Г.Алтансүх танилцууллаа. Өнөөдрийн хурлын дэг, хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хурлаар 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах, 2020 онд олгосон ногдол ашгийн тайлан танилцуулах, 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах, Компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах тухай, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай гэсэн 5 асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлыг танилцуулсны дараа хэлэлцэх асуудалтай холбоотой асуултуудыг хувьцаа эзэмшигчдээсээ хүлээн авна. Үүний дараагаар санал хураалтын явагдаж байх хооронд ирсэн асуултуудад хариулт өгнө. Ингээд хурлаас гарсан шийдвэрийг хурлын дарга хувьцаа эзэмшигчдэд танилцуулан хурлаа хаах юм.

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Хурлыг нээж нээлтийн үг хэлсэн хурлыг даргалж байгаа ТУЗ-ийн дарга Ганхуяг захиралдаа талархсанаа илэрхийлье. Мөн Ард Даатгал ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүдээс гадна өнөөдрийн хурлыг сонирхон оролцож буй хүмүүст талархал илэрхийлье.

2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах

Ард Даатгал ХК нь 1994 онд үүсгэн байгуулагдсан. 2018 онд IPO хийж олон нийтийн хөрөнгө оруулалттай хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. Компанийн хувьд нийт 100 орчим ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хөдөө орон нутагт 21 салбартайгаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

2020 оны онцлох үйл явдлууд:

- А 2020 онд 166 мянган даатгуулагчаас 15.7 тэрбум төгрөгийн хураамжийн орлого хуримтлуулсан байна.
- А 4,824 даатгуулагчид 4.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.
- А 2019 оны цэвэр ашгаас 850 сая төгрөгийн ногдол ашиг байдлаар хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилж үнэт цаасны дансаар нь дамжуулан олгосон байна.
- А 2020 оны 1 улирлаас эхлэн Ард Апп дээр даатгал хийх боломжтой болсон.
- А 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлыг анх удаа цахимаар амжилттай зохион байгуулсан.
- А Ковид 19 цар тахлын эрсдэлийг олон улсын эрүүл мэндийн даатгал болон дотоодын эрүүл мэндийн даатгалыг харилцагч нартаа санал болгон ажиллаж байна.
- А Даатгуулагч, харилцагч нартаа 45 сая Ард Койныг урамшуулал болгон олгосон байна.
- А Даатгалын үйл ажиллагааг цахимжуулах ажлын хүрээнд Гэрэгэ Киоскоор дамжуулан Жолоочийн хариуцлагын даатгал хийх боломжтой болсон.
- А Компанийн даатгалын үйл ажиллагаанд CRM нэвтрүүлэн ажиллаж байна.
- А Хөдөө орон нутагт “Хөрөнгө оруулагч-Хөдөө орон нутагт” аяныг хамтран зохион байгуулж байна.

2020 оны санхүүгийн гол үзүүлэлтүүд:

2020 оны эцсийн байдлаар манай компанийн нийт хураамжийн орлого 15.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн, 4.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагч нарт олгож 2.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. 2021 оны 1 улирлын байдлаар 2.7 тэрбум төгрөгийн хураамжийн орлого хуримтлуулан, хөрөнгө оруулалтын орлого 9.4 тэрбум төгрөгт хүрснээр 6.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаа.

2020 оны эцсийн байдлаар нийт хөрөнгө 28.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 38 хувиар өссөн бол 2021 оны 1 улирлын байдлаар нийт хөрөнгө 35.1 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс даруй 22 хувиар өссөн байна.

2020 оны эцсээр бид нийт 2,069 хувьцаа эзэмшигчидтэй байсан бол 2021 оны 3 сарын 31-ний өдрийн тархалтын мэдээгээр 8,142 хувьцаа эзэмшигчтэй болсон. Өчигдрийн байдлаар 9,300 гаруй хувьцаа эзэмшигчтэй болсон мэдээлэл ирсэн байна. 2021 оны 3 сарын 31-ний байдлаар компанийн хувьцааны 33.8 хувийг нийт 8,105 дотоодын иргэд, 21 гадаад иргэд, 66.2 хувийг 16 аж ахуйн нэгж тус тус эзэмшиж байна.

2021 оны 1 улирлын байдлаар хувьцааны үнэ 705-1,590 төгрөгийн хооронд хэлбэлзэж, улирлын эцэст 1,455 төгрөгийн үнэтэй хаагдсанаар компанийн зах зээлийн үнэлгээ 36.4 тэрбум төгрөгт хүрээд байна. IPO хийснээс хойш нийт 14.5 сая ширхэг хувьцаа арилжаалагдаж, 12.6 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд Монголын Хөрөнгийн Бирж дээрх хамгийн хөрвөх чадвар сайтай хувьцаануудын нэг байсаар байна.

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг та бүхэнд танилцууллаа. Та бүхэнд асуух, тодруулах зүйл байвал асуулт хэсэгт өөрсдийн хүссэн асуултаа оруулаад асуугаарай. Асуулт хариултын цаг дээр хариултуудыг нь өгөөд явъя.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг: За баярлалаа. Хурлын хэлэлцэх асуудлын дагуу дараагийн асуудал 2020 онд олгосон ногдол ашгийн тайланг Цогбадрах захирал танилцуулна.

2020 онд олгосон ногдол ашгийн тайлан танилцуулах

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: 2019 онд Ард Даатгал ХК нь 1.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд 2020 оны 2 сарын 17-ны өдрийн ТУЗ-ийн шийдвэрээр нэгж хувьцаанд 34 төгрөг, нийт 850 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн. Тус шийдвэрийн дагуу 2020 оны 5 сарын 20-ны өдөр “Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлсэн байна.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг: За баярлалаа. Дараагийн асуудал 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах байгаа Цогбадрах захирал танилцуулаад явах уу?

2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: За тэгье. Манай компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2019 онд болсон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгогдон томилогдсон бөгөөд компанийн дүрмийн дагуу 2 жилийн хугацаатай сонгогдож ажилладаг.

Ердийн гишүүд:

- ▲ Ч. Ганхуяг
- ▲ О. Одбаяр
- ▲ Б. Золбоо
- ▲ Ч. Ганзориг
- ▲ С. Оргил
- ▲ Г. Цогбадрах

Хараат бус гишүүд:

- ▲ З. Ариун
- ▲ Б. Болорчимэг
- ▲ И. Сэр-Од

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны хувьд улирал тутам хуралдаж явдаг бөгөөд Хороод мөн адил улирал тутам хурал хийж зохих зөвлөмж өгч ажилдаг байна. 2020 онд нийт 6 удаа хуралдаж, 2 удаа эчнээ санал хураалтаар шийдвэр гарган ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд гурван хороо ажиллаж байгаа бөгөөд Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо, Аудитын хороо гэсэн хороод өөр өөрсдийн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

Дарга: Ч. Ганзориг

Гишүүд: Б. Болорчимэг, З. Ариун

Нарийн бичиг: Т. Батцэнгэл

Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо

Дарга: Б. Золбоо

Гишүүд: С. Оргил, Г. Цогбадрах, И. Сэр-Од, Б. Болорчимэг

Нарийн бичиг: Г. Баярбат

Аудитын хороо

Дарга: З. Ариун

Гишүүд: И. Сэр-Од, О. Одбаяр

Нарийн бичиг: П. Бямбасүрэн

Хороодын тайланг хорооны дарга нар тус тус танилцуулна.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг: За тэгье. Миний хувьд Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны даргаар ажиллаж байна. 2020 онд нийт 4 удаа хуралдсан бөгөөд хороогоор Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой асуудлууд, Гүйцэтгэх захирлын үнэлгээний асуудал, ТУЗ-ийн төсөв, ТУЗ-ийн нарийн бичгийг сонгох зэрэг асуудлуудыг тус тус хэлэлцэж ТУЗ-д зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн З.Ариун: Миний хувьд 2020 оноос Аудитын хорооны даргаар томилогдон ажиллаж байна. Энэ онд Аудитын хорооны дүрмийг шинэчилж илүү өргөн цар хүрээтэй болгон үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаа. Хороогоор салбаруудад хийгдсэн шалгалтын тайлан, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайлан, 2019 оны аудитлагдсан тайлан, 2021 оны аудитын албаны ажлын төлөвлөгөө зэрэг асуудлуудыг хэлэлцэж ажилласан байна.

ТУЗ-ийн гишүүн Б.Золбоо: Сайн байцгаана уу. Миний хувьд 2018 оноос эхлэн Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хорооны даргаар ажиллаж байна. Бидний хувьд улирал бүр буюу 4 удаа хуралдсан байна. Хурлаар улирлын үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, аудитлагдсан тайлан, эрсдэлийн тайлан, ногдол ашиг хуваарилах, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн хүрээнд гадаад төлбөр тооцооны тайлан, шүүхийн маргааны асуудал, 2021 оны компанийн төсөв төлөвлөгөө, ТУЗ-ийн төсөв зэрэг асуудлуудад зөвлөмж өгч ТУЗ-д мэдээлэлж ажилласан байна.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг: За баярлалаа. Манай Төлөөлөн удирдах зөвлөл нь гурван хороонд хуваагдан ажиллаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр гаргах шийдвэрийг хялбарчлахын тулд хороодоос зөвлөмж гаргах байдлаар ажилладаг байна.

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: За бусад мэдээлэлтэй холбоотой хэсгийг би танилцуулъя. 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Ганзориг захирал танилцуулъя. 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Грант Торнтон аудит ХХК хөндлөнгийн аудит хийсэн бөгөөд тус аудитын шалгалтын дүгнэлт Эерэг дүгнэлт гарсан бөгөөд энэ тайлагналыг 2021 оны 3 сарын 26-ны өдөр өдөр тутмын сонин хэвлэлд мэдээлэлсэн бөгөөд мөн Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал болон компанийн веб сайтад байршуулсан байна. Энэ онд олгох ногдол ашгийн талаар хувьцаа эзэмшигчдээс нилээн асуулт ирдэг бөгөөд 2021 оны 2 сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн шийдвэрээр 2020 оны цэвэр ашгаас нийт 1 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэр гарсан байна. Энэ нь нэгж хувьцаанд 40 төгрөгийн ногдол ашиг болохоор байна. Бүртгэлийн өдрийн хувьд 2021 оны 3 сарын 31-ний өдрөөр тогтоосон.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг: ТУЗ-ийн дүгнэлт батлах тухай, Төлөөлөн Удирдах Зөвлөл нь гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлсэн ажлын үр дүнд сэтгэл хангалуун байгаа ба компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлд хангалттай гэсэн дүгнэлтийг хийж, компанийн Гүйцэтгэх захиралд бүрэн итгэл хүлээлгэн ирээдүйд тавьсан зорилго, зорилтууддаа хүрэхэд ТУЗ-ийн зүгээс бүх талаар дэмжин, улирал бүр гүйцэтгэлийг тайлагнаж явахыг үүрэгдсэн бөгөөд борлуулалтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардлыг хэмнэх, чанарын үзүүлэлтүүдийг зах зээлийн тэргүүний төвшинд барьж явах чиглэл өгч ажиллаж байна. Дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн санал хураалтаар батлахаар байгаа та бүхэн live.ard.mn цахим хаягаар орж санал өгөх заавартай танилцаж саналаа өгөх боломжтой байна. Та бүхэн санал өгөх заавартай сайн танилцаарай гэж хүсье. За дараагийн хэлэлцэх асуудал буюу Компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах тухай асуудал руу оръё.

Компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах тухай

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: За компанийн төв оффист хаягийн өөрчлөлт орж байгаатай холбогдон хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах шаардлагатай тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулан батлуулахаар хэлэлцэж байна. Компанийн хувьд өмнө Ард Санхүүгийн Нэгдэл компанийн байранд байршиж байсан бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний охин компаниудын үйл ажиллагаа өргөжихийн хирээр тус оффист багтахгааргүй болсон тул 2021 оны 4 сарын эхээр Сентрал Тауэрт нүүж орсон тул компанийн дүрмийн 1.5-д “Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байр, 2 давхарт, утас: 7720 0088, www.arddaatgal.mn, info@arddaatgal.mn” гэж заасныг “Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сентрал Тауэр, 13 давхарт, 1305 тоот утас: 7720 0088, www.arddaatgal.mn, info@arddaatgal.mn” гэж өөрчлөлт оруулж Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, Санхүүгийн Зохицуулах Хороонд мэдээлэх зэрэг үүрэгтэй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг: За дараагийн асуудал Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох сонгуулийг явуулах ёстой. ТУЗ-ийн гишүүнд 10 нэр дэвшигч байгаа бөгөөд ердийн 6 гишүүн, хараат бус гишүүн 3, ТУЗ нь нийт 9 гишүүнтэй байх ёстой. Хувьцаа эзэмшигчид ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулгатай танилцаад дараа нь саналаа өгөх ёстой байна. Нэр дэвшигчдийнхээ танилцуулга руу орё.

ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид өөр өөрсдийгөө танилцуулав.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг: За бүх нэр дэвшигчид танилцуулгаа хийж дууслаа. Бүгдэд нь амжилт хүсье. Хувьцаа эзэмшигчид маань одоо явуулах санал өгөх заавартай сайн танилцаарай нэг л удаа тухайн асуудал дээр санал өгөх бөгөөд дахин санал өгөх боломжгүйг анхаараарай.

Санал өгөх заавар видеогоор хүргэв.

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: За хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцож байгаа нийт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч та бүхэндээ талархал илэрхийлье. Сая та бүхэнд саналын хуудсыг хэрхэн цахимаар бөглөх зааварчилгаатай бүрэн танилцаж мэдээлэл авсан байх гэж найдаж байна. Сая хуралтай холбоотой ирүүлсэн асуултууд надад ирлээ. Та бүхэнд эхнээс хариулъя.

Асуулт 1: Санал өгөх онлайн заавар өгөх үү?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Сая онлайн зааврыг дэлгэрэнгүй хүргүүлсэн.

Асуулт 2: 2021-2022 онд хийх шинэ ажил үйлчилгээ юу юу байна вэ?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Би саяхан 2021 оны 1 улирлын тайлангийн хурал дээрээ танилцуулж байсан. Энэ жил 20 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой, 10 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллах зорилт тавин ажиллаж байна. Үйл ажиллагааны хувьд даатгалын үйлчилгээг цахимаар даатгуулагч харилцагч нартаа олгохоор ажиллаж байна.

Асуулт 3: Ногдол ашгийн талаар мэдээлэл авъя?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Энэ жил нийт 1 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгох бөгөөд нэгж хувьцаанд 40 төгрөг хуваарилагдаж байна. Бид 2021 оны 7 сарын 30-наас өмнө олгохоор төлөвлөөд ажиллаж байна.

Асуулт 4: Нэмж хувьцаа гаргах уу?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Одоогийн байдлаар нэмж хувьцаа гаргах бодолгүй байна. Хэрвээ ийм шийдвэр гараад явбал тухай бүрт нь мэдээллээд явна.

Асуулт 5: ТУЗ-д 9 гишүүн сонгох уу?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Тийм. Ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүн сонгохоор байгаа бөгөөд энэ жилийн сонгуульд хараат бус гишүүнд 4 хүн нэр дэвшиж байгаа тул 3 хүнийг сонгох боломжтой гэсэн үг.

Асуулт 6: Гүйцэтгэх захирал ТУЗ-д байж болдог юм уу?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Боломжтой. Ихэнх хувьцаат компаниуд ТУЗ-д гүйцэтгэх захирлыг оруулж ажилладаг. Энэ нь өөрөө хэд хэдэн зорилготой байдаг бөгөөд нийт ажиллагсдын эрх ашгийг хамгаалах, харилцагч нарын эрх ашгийг хамгаалах, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг зорилгууд байдаг.

Асуулт 7: Шангри-Ла-тай холбоотой шүүхийн шийдвэр гарсан байна. Энэ юу болж байгаа вэ?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Энэ нь 2011 онд хийгдсэн гэрээнээс үүссэн асуудал бөгөөд бидэнд 2016 оноос мэдэгдэж бүхий л шатны шүүхийн шатаар

дамжиж боломжит бүх арга хэмжээг авсан боловч зөвхөн даатгалын гэрээ биш, баталгаа байсан гэдэг шийдвэрийг шүүхээс гаргаж байгаа тул 1.2 тэрбум төгрөгийн хохирлыг төлөхөөр болсон. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг хувьцаа эзэмшигч болж орж ирэхээс өмнө үүссэн асуудал бөгөөд компанийн нэр хүнд, эрх ашгийг хамгаалаад үүнийг төлөхөөс өөр аргагүй байдалд орж байгаа бид энэ хохирлыг төлнө. Бид сая 2021 оны 1 улирлын үйл ажиллагааг мөн танилцуулсан бөгөөд тайлант хугацааны санхүүгийн тайланд тус хохиролтой холбоотой сан байгуулсан байгаа бөгөөд 1.2 тэрбум төгрөгийн сан байгуулсан хэдий ч цэвэр ашиг 6.7 тэрбум төгрөг байна.

Асуулт 8: Урамшууллын койнууд хэзээ орох вэ?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой урамшууллын койнууд ирэх 7 хоногоос орох боломжтой байна.

Асуулт 9: Даатгал авах бүрт урамшуулал өгч байгаа юу?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал болон цалингийн зээлийн даатгалаас бусад иргэдийн сайн дурын бүх даатгал дээр урамшуулал олгож байна.

Асуулт 10: Харааны бэрхшээлтэй иргэд уншихад хэцүү байна?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: За бид цаашид бодолцох хэрэгтэй юм байна. Гэхдээ бид энэ удаагийн хурал дээр дохионы хэллэгийг ашиглаж байгаа гэдэг нь шинэлэг алхам болж байгаа гэж бодож байна.

Асуулт 11: Хүнд өвчний даатгал гэж юу вэ?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Энэ нь эрүүл мэндийн даатгал дээр хууч, ужиг өвчнүүдийг даатгалын хасалтаар оруулдаг. Хасалтаар ороод байгаа өвчлөлүүдийг даатгуулагч нартаа боломж олгох байдлаар тэргүүлэх зэрэглэлийн хэд хэдэн компаниуд хамтран туршилтаар нэвтрүүлж эхэлж байна. Үүнтэй холбоотой мэдээллийг тусдаа live бэлдэн хүргүүлье.

Асуулт 12: Яг одоо хувьцаа авбал яаж авах вэ?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Яг одоо бол Монголын Хөрөнгийн Биржийн арилжаа хаагдсан байгаа тул маргаашнаас эхлэн ажлын өдөр бүр 10:00-13:00 цагийн хооронд арилжаа явагддаг тул тухайн үед өөрийн харилцдаг үнэт цаасны брокероор дамжуулан захиалга өгч арилжаанд оролцох боломжтой.

Асуулт 13: 2021 оны 3 сарын 31-нд хувьцаа авахаар захиалаад тухайн өдрөөс хойш хувьцааны арилжаа нь хийгдсэн хүнд ногдол ашиг авах уу?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Компанийн хувьд ногдол ашиг олгох бүртгэлийн өдрийг 2021 оны 3 сарын 31-ний өдрөөр тогтоосон тул Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс тухайн өдрөөр тасалбар болгон гаргаж өгсөн хувьцаа эзэмшигчдийн жагсаалтын дагуу ногдол ашиг олгогдоно. Өөрөөр хэлбэл бүртгэлийн өдрөөс хойш хувьцаа авсан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгох боломжгүй.

Асуулт 14: Ард Даатгал Банкны IPO-д оролцох уу?

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан дүрэм журмын хүрээнд хөрөнгө оруулалт хийх боломжтой байдаг бөгөөд Ард Даатгал ХК банкны IPO-д оролцох боломж нээлттэй байгаа, зах зээлд гарах шинэ IPO-нд оролцоно гэсэн хүлээлттэй байна.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг: За одоо тооллогын комиссын дарга Алтансүх санал хураалтын дүнг танилцуулна.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Та бүхэнд тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №2

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай санал хураалтад 17,680,039 ширхэг хувьцаа буюу 70.72 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - 1.1. Зөвшөөрсөн 17,611,810 ширхэг буюу 99.61%.
 - 1.2. Татгалзсан 3564 ширхэг 0.02%.
 - 1.3. Түдгэлзсэн 9584 ширхэг 0.05% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
2. Хүчингүй болсон саналын хуудасны тоо:

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай санал хураалтад цахимаар саналаа өгсөн 45 хувьцаа эзэмшигчдийн нийт 13,709 ширхэг хувьцаа буюу 0.08%-ийн санал хүчингүй байна.

**АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №3**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дахь хэсгийг үндэслэн, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах тухай тухай санал хураалтад 17,680,039 ширхэг энгийн хувьцаа буюу 70.72 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - 1.1. Зөвшөөрсөн 17,403,976 ширхэг буюу 98.43%.
 - 1.2. Татгалзсан 6080 ширхэг 0.03%.
 - 1.3. Түдгэлзсэн 1844 ширхэг 0.01% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
2. Хүчингүй болсон саналын хуудасны тоо:
Компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах тухай санал хураалтад цахимаар саналаа өгсөн хувьцаа эзэмшигчдийн нийт 19,885 ширхэг хувьцаа буюу 0.11%-ийн санал хүчингүй байна.

**АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №4**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйл 77.1 болон 77.2 дугаар хэсгийг үндэслэн. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай санал хураалтад 17,608,039 ширхэг энгийн хувьцаа буюу 70.72 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Саналын тоо
---	---	-------------

Ердийн гишүүд

1	Чулууны Ганхуяг	18,742,346
2	Одончимэдийн Одбаяр	17,013,352
3	Галбадрахын Цогбадрах	17,305,319
4	Батбилэгийн Золбоо	17,065,342
5	Чулууны Ганзориг	17,000,629
6	Сүхдоржийн Оргил	18,378,947

Хараат бус гишүүд

1	Зоригтын Ариун	16,974,254
2	Баатарзоригтын Болорчимэг	16,905,286
3	Ичинхорлоогын Сэр-Од	16,008,397

4	Батаагийн Чойжил	201,478
---	------------------	---------

2. Хүчингүй болсон саналын хуудасны тоо:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай санал хураалтад цахимаар саналаа өгсөн 82 хувьцаа эзэмшигчдийн нийт 158,026 ширхэг санал хүчингүй байна.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулж дууслаа. Баярлалаа.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг: Тооллогын комиссын дарга Алтансүх танд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалт амжилттай явж дүнгээ танилцууллаа. Нийт сонгогдсон ердийн болон хараат бус гишүүддээ баяр хүргэе. Мөн энэ удаагийн хуралд хараат бус гишүүнд нэрээ дэвшүүлсэн Чойжил нэр дэвшигчдээ баярлалаа. За одоо хурлаас гарсан шийдвэрийн та бүхэнд танилцуулъя.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №01/21

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2021 оны 4 сарын 28-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 21/02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №02/21

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 21/04 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Чулуун овогтой Ганхуяг, Одончимэд овогтой Одбаяр, Галбадрах овогтой Цогбадрах, Батбилэг овогтой Золбоо, Чулуун овогтой Ганзориг, Сүхдорж овогтой Оргил нарыг, хараат бус гишүүнээр Зоригт овогтой Ариун, Баатарзоригт овогтой Болорчимэг, Ичинхорлоо овогтой Сэр-Од нарыг тус тус сонгохыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Г.Баярбат)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №03/21

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 2021 оны 4 сарын сарын 28-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 21/03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.5-д “Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар 14200, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305 тоот” гэж өөрчлөн, өөрчлөлтийг компанийн дүрэмд тусгахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, дүрмийн өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх, Санхүүгийн Зохицуулах Хороонд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Цогбадрах)-д даалгасугай.

Ийнхүү хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр тогтоолыг баталсныг мэдэгдье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг баталснаар амжилттай өндөрлөлөө. Хурлаа амжилттай зохион байгуулсан Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, удирдлагын баг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн удирдлагын багт талархлаа илэрхийлье. Хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа. Хурлыг хаасныг албан ёсоор мэдэгдэж байна.


ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Г.БАЯРБАТ